



ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК-Н ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

№001/007/Н01/20240313-001

2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл 59.4, 60 дугаар зүйл 60.1, 60.2, 76 дугаар зүйл, 76.1.2, 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн №004/007/20240131-004 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 болон 4 дүгээр зүйлийн 4.2.2 дахь заалтыг, 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн хурлын эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 11.00 цагт **Монгол Улс, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандийн гудамж 39, Корпорейт зочид буудал Конвеншн Центрийн 5 давхарт Улаанбаатар танхимд** болон **gazarshim.mn** цахим хуудсаар дамжуулан цахимаар болон танхимаар хуралдуулсугай.
2. **Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.**
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржэд 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор шаардлагатай баримт бичгийн хамт тус тус хүргүүлсүгэй.
5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын аль нэг сонин, “Газар шим үйлдвэр” ХК-ийн цахим хуудас болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн дотор нийтэд мэдээлсүгэй. Хурал хуралдуулах тухай давтан зарыг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтэд мэдээлсүгэй.
6. Хурлын дэг, гарах шийдвэрийн төслүүд, санхүү, үйл ажиллагааны тайлан, тайлангийн талаарх дүгнэлт, ТУЗ-ийн 2024 оны төсвийн санал болон холбогдох

бусад баримт бичгийг бэлэн болгож, 2024 оны 03 сарын 29-ний өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.

7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлийн хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 11.00 цагаар тасалбар болгосугай.
8. Хурлын даргаар Гүйцэтгэх захирал Ц.Ганбатыг томилсугай.
9. Дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

- a. Хурал зохион байгуулах комиссын дарга: “Газар шим үйлдвэр” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ганбат

- b. Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

“Газар шим үйлдвэр” ХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан Захирал
З.Байгалмаа

“Газар шим үйлдвэр” ХК-ийн Захиргаа, хүний нөөцийн албаны дарга
Б.Энхбилэг

“Газар шим үйлдвэр” ХК-ийн Хуулийн зөвлөх Ц.Батнасан

“Газар шим үйлдвэр” ХК-ийн Захиргааны менежер Б.Хулан

10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

- a. Тооллогын комиссын дарга: Би Ди Сек ҮЦК-ийн мэргэжилтэн Б.Онон

- b. Тооллогын комиссын гишүүд:

Би Ди Сек ҮЦК-ийн мэргэжилтэн Б.Энхжин

Би Ди Сек ҮЦК-ийн мэргэжилтэн М.Мишээл

11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хурал зохион байгуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахад шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

12. Хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ц.Ганбатад даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ш.АЛТАНБАГАНА